

UCS 1409B:2022

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ




Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног
төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага

*Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 23-р тогтоолоор батлав.*



ГАРЧИГ

1. Хамрах хүрээ	5
2. Эшлэл авсан баримт бичгүүд	5
3. Нэр томьёо, тодорхойлолт	5
4. Гадна мэдээллийн байгууламжид тавих шаардлага	6
5. Талбайн хучилтад тавих ерөнхий шаардлага	6
6. Тоног төхөөрөмжид тавих шаардлага	8
7. Хөгжлийн бэрхшээлтэй иргэний хүртээмжтэй байдал	9
8. Статик тоног төхөөрөмж	10
9. Динамик тоног төхөөрөмж	10
10. Тоног төхөөрөмж байрлуулах	11
11. Тоног төхөөрөмжийг суурилуулах	13
12. Тоног төхөөрөмжийн материалд тавих шаардлага	14
13. Тоног төхөөрөмжийг ашиглах заавар болон мэдээллийн хэсэг	14
14. Чийрэгжүүлэх талбай нэмэлт тоноглол	16
15. Ашиглалт, засвар үйлчилгээ, хяналт	16
16. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар	18
17. Шалгуур үзүүлэлт	20
Ашигласан материалын жагсаалт	21

ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1. Хөдөлгөөний болон тоног төхөөрөмжийн орон зай (Жишээ зураг).....	8
Зураг 2. Хүзүү, нугасанд ачаалал өгөх	8
Зураг 3. Нуруу, нугасанд ачаалал өгөх	8
Зураг 4. Олон талт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан чийрэгжүүлэх тоног төхөөрөмж (Жишээ зураг).....	9
Зураг 5. Статик тоног төхөөрөмж (Жишээ зураг)	10
Зураг 6. Динамик тоног төхөөрөмж (Жишээ зураг)	10
Зураг 7. Түгжээ, холбогч, хамгаалалт, ил гарсан хэсгийн зөвшөөрөгдсөн хэмжээ /мм-ээр/	13
Зураг 8. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн суурилуулалтын жишиг зураг.....	14
Зураг 9. Тоног төхөөрөмж дээрх санамж, мэдээллийн хэсэг (Жишээ зураг)	15
Зураг 10. Хэрэглэгчдэд зориулсан талбайн мэдээллийн самбар (Жишээ зураг)	15
Зураг 11. Нэмэлт гэрэлтүүлэг бүхий чийрэгжүүлэх талбай (Жишээ зураг).....	16
Зураг 12. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар-1 (Жишээ зураг).....	18
Зураг 13. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар-2 (Жишээ зураг).....	18
Зураг 14. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-1 (Жишээ зураг)	18
Зураг 15. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-2 (Жишээ зураг)	19
Зураг 16. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-3 (Жишээ зураг)	19
Зураг 17. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-4 (Жишээ зураг)	19
Зураг 18. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-4 (Жишээ зураг)	19

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1. Талбайн давхаргын зузааны зохистой хэмжээ (Жишээ зураг)	7
Хүснэгт 2. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төрөл /зориулалтаар/	9
Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон дасгалын орон зай	12
Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн хяналт, үнэлгээ хийх үзүүлэлт	17
Хүснэгт 5. Хүлээн авах шалгуур үзүүлэлт.....	20



**НИЙСЛЭЛИЙН
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН
ТОГТООЛ**

2022 оны 03 сарын 24 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

┌ Нийтийн эзэмшлийн эд хөрөнгөд ┐
хамаарах хотын стандартыг батлах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1.15 дахь заалт, 35 дугаар зүйлийн 35.1.13 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.3 дахь заалт; Захиргааны ерөнхий хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь хэсэг, Стандартчилал, техникийн зохицуулалт, тохирлын үнэлгээний итгэмжлэлийн тухай хуулийн 10¹ дүгээр зүйлийн 10^{1.1} дэх хэсгийг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:


1. Нийслэлийн иргэдийн эрүүл аюулгүй, амьдрах эрхийг хангахад чиглэсэн Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө бүлэгт хамаарах дор дурдсан стандартуудыг хавсралтаар баталсугай. Үүнд:

- 1.1. UCS1402B:2022 “Нийтийн эзэмшлийн талбайд байгуулах усан оргилуурт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.2. UCS1401B:2022 “Нийтийн бие засах газрын төлөвлөлт байгуулалтад тавих техникийн шаардлага” хотын стандарт
- 1.3. UCS1403B:2022 “Гадна мэдээллийн байгууламжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.4. UCS 1404B:2022 “Саравч, сүүдрэвчинд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.5. UCS1405B:2022 “Хүүхдийн тоглоомын талбайн ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.6. UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.7. UCS1407B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.8. UCS1408B:2022 “Хөшөө дурсгал, хүндэтгэлийн самбарт тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.9. UCS1409B:2022 “Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлт, тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага” хотын стандарт
- 1.10. UCS1410B:2022 “Хашаа, хайс, хашлаганд тавих ерөнхий шаардлага” хотын стандарт

1110100320

2.Батлагдсан хотын стандартуудыг мөрдүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Д.Сумъяабазар)-д даалгасугай.

3.Энэхүү тогтоолыг 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрөөс мөрдсүгэй.

ДАРГА  Ж.БАТБАЯСГАЛАН



Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын
2022 оны 03-дугаар сарын 24-ний өдрийн 23
дугаар тогтоолын есдүгээр хавсралт

НИЙТИЙН ЭЗЭМШЛИЙН ЭД ХӨРӨНГӨ

UCS 1409B:2022 “ЧИЙРЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙН ТӨЛӨВЛӨЛТ, ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА” ХОТЫН СТАНДАРТ

1. ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү стандартыг нийтийн зориулалттай гадна чийрэгжүүлэх талбайг байгуулахад хэрэглэнэ. Энэхүү стандарт нь хүүхдийн тоглоомын талбайд хамаарах зүйлсийг зохицуулахгүй болно.

2. ЭШЛЭЛ АВСАН БАРИМТ БИЧГҮҮД

Энэхүү стандарт нь эш татсан дараах хууль, барилгын норм ба дүрэм, стандартын шаардлагыг бүрэн хангах бөгөөд өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн эх материалыг үндэслэл болгоно.

- БНБД 3.01.06-90 Барилгын орчны тохижилтын ажил;
- БНБД 30.01.03 Хот, тосгоны төлөвлөлт барилгажилтын норм ба дүрэм.

3. НЭР ТОМЬЁОНЫ ТОДОРХОЙЛОЛТ

Чийрэгжүүлэх талбай – гэж нийтийн эзэмшлийн талбайд олон нийт чөлөөт цагаа зөв, боловсон өнгөрүүлэх, идэвхтэй дасгал хөдөлгөөн хийх, бие бялдраа хөгжүүлэх зориулалт бүхий тоног төхөөрөмжөөр тоноглогдсон талбай;

Ашиглалтын хэсэг – гэж дасгал хийгдэж буй төхөөрөмжийн хэсэг;

Хөдөлгөөний орон зай – гэж чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн орчны хязгаарлалтын шинж чанарыг харуулсан орон зай;

Дасгалын орон зай – гэж дасгал хийхэд шаардлагатай орон зай;

Динамик тоног төхөөрөмж – гэж хөдөлгөөнт хэсэгтэй тоног төхөөрөмж;

Статик тоног төхөөрөмж – гэж үл хөдлөх, хөдөлгөөнгүй хэсэгтэй тоног төхөөрөмж;

Чөлөөт уналтын өндөр – гэж тоног төхөөрөмжийн хамгийн доод хэсэг буюу гадаргуугаас тоног төхөөрөмжийн хамгийн дээд цэг хүртэлх хоорондын өндрийн зай.









4. ГАДНА МЭДЭЭЛЛИЙН БАЙГУУЛАМЖИД ТАВИХ ШААРДЛАГА

- 4.1. Чийрэгжүүлэх талбайг иргэдийн эрүүл, аюулгүй, тав тухтай орчинд дасгал, идэвхтэй хөдөлгөөн хийх нөхцөл бололцоог хангаж, гудамж талбайн тохижилт, инженерийн байгууламжтай уялдуулан төлөвлөнө.
- 4.2. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг цэцэрлэгт хүрээлэн, орон сууцны нийтийн эзэмшлийн гудамж, талбайд төлөвлөн байршуулна.
- 4.3. Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийг хүн амын хэрэгцээ, шаардлага, тухайн бүс нутгийн хүн амын нягтаршил зэргийг тооцсоны үндсэн дээр аль байршилд хэдий хэмжээний тоног төхөөрөмж байрлуулахыг нарийн төлөвлөнө.
- 4.4. Чийрэгжүүлэх талбайн зах хэсэгт амрах, суух зориулалт бүхий нийтийн эзэмшлийн сандал, хогийн сав байршуулж болно.
- 4.5. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж бүхий дасгалын талбай нь бага насны хүүхэд болон 1400 мм-ээс доош өндөртэй хүнд зориулагдаагүй бөгөөд орчны аюулгүй байдал болон гэнэтийн эрсдэл, гэмтлийг тооцон эрсдэлийн /SWOT/ шинжилгээ хийж, судалгааны үр дүнд суурилан талбайн төлөвлөлтийг гаргах шаардлагатай.
- 4.6. Чийрэгжүүлэх талбайг хөгжлийн бэрхшээлтэй хүн чөлөөтэй ашиглах нөхцөлийг бүрдүүлсэн байна.
- 4.7. Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж нь гарал үүслийн болон чанарын баталгааны гэрчилгээтэй байна.
- 4.8. Тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааварчилгааны дагуу суурилуулна.
- 4.9. Чийрэгжүүлэх талбайг дэд бүтэц болон гадна орчны тохижилттой уялдуулан төлөвлөх бөгөөд нийтийн эзэмшлийн эд хөрөнгө, гэрэлтүүлэг зэргийг батлагдсан зураг төслийн дагуу байрлуулна.

5. ТАЛБАЙН ХУЧИЛТАД ТАВИХ ЕРӨНХИЙ ШААРДЛАГА

- 5.1. Чийрэгжүүлэлтийн талбайн гадаргуу нь аюулгүй байдлыг хангасан байх бөгөөд чөлөөт уналтын өндөр болон төхөөрөмжийн төрлөөс хамааран хэрэглэгчдэд гэмтэл учруулахааргүй байна.
- 5.2. Чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмжийн төрөл болон чөлөөт уналтын хэмжээнээс хамааран гадаргуун материалын зузааныг тодорхойлно.
- 5.3. Чийрэгжүүлэлтийн талбайн гадаргуугийн зузааны хэмжээг Хүснэгт 1-д үзүүлэв.

Хүснэгт 1. Талбайн давхаргын зузааны зохистой хэмжээ (Жишээ зураг)

	Гадаргуугийн материал ^а	Тайлбар	Давхаргын зузааны ^а хэмжээ /мм/	Чөлөөт уналтын өндөр /мм/
1	 Бетон/чулуун (Жишээ зураг)	-	-	≤1000
2	 Битум /цардмал/ (Жишээ зураг)	-	-	≤1000
3	 Зүлэг (Жишээ зураг)	-	-	≤1500
4	 Хөрс (Жишээ зураг)	-	-	≤1200
5	 Модны үртэс (Жишээ зураг)	Зориулалтын дагуу механик аргаар буталсан мод. Модны холтос, навч байж болохгүй. 5 мм-ээс 30 мм-ийн ширхэглэлтэй байна.	200	≤ 2000
			300	≤ 3000
6	 Ургамлын холтос, хальс (Жишээ зураг)	Ургамал, модны төрлөөс хамаараад 20 мм-ээс 80 мм-ийн ширхэглэлтэй байна.	200	≤ 2000
			300	≤ 3000
7	 Элс ^{b,c} (Жишээ зураг)	0,2 мм-ээс 2 мм-ийн ширхэглэлтэй	200	≤ 2000
			300	≤ 3000
8	 Хайрга ^{b,c} (Жишээ зураг)	2 мм-ээс 8 мм-ийн ширхэглэлтэй	200	≤ 2000
			300	≤ 3000
9	Бусад материал ба давхаргын гүн	EN 1177 НИС шалгуур, туршилтын дагуу	Шалгуур, туршилтын үндсэн дээр тооцно.	

а. Сул дүүргэх материалыг хамгийн бага давхаргын зузаан дээр 100 мм нэмнэ.


б. Шаварлаг хэсгүүд байж болохгүй бөгөөд EN 933-1 стандартын дагуу шигшсэн байна.

в. Хөдлөх хэсэг ихтэй, суурь, тулах цэг нь гүн, бат бэх байх шаардлагатай тоног төхөөрөмжид тохиромжгүй.

- 5.4. Чийрэгжүүлэх талбайн гадаргууг дасгал, хөдөлгөөн хийх үед тоног төхөөрөмжөөс унахад чөлөөт уналтаас үүсэх хүчийг сааруулах, багасгах, гэмтэл учруулахгүй байх зорилгоор талбайн гадаргуун материалыг сонгон хэрэглэнэ.
- 5.5. Хайрга, элс, үртэс зэрэг нөхөн сэргээж байх шаардлагатай гадаргуунууд нь тусгай арчилгаа шаарддаг бөгөөд өндөр ачаалалтай, чийрэгжүүлэх талбайд засвар үйлчилгээ, нөхөн сэргээлтийг тогтмол хийж байх шаардлагатай.
- 5.6. Талбайн гадаргуу нь хэрэглэгч тээгэлдэх, бүдрэхээргүй тэгш, цэвэрлэхэд хялбар, хурц ирмэггүй, гогцоогүй байх ба гадаргуун засвар, арчилгааг тогтмол хийнэ.

6. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИД ТАВИХ ШААРДЛАГА


- 6.1. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж нь хэрэглэгчид зориулалтын дагуу ашиглахаар ойлгомжтой загвар, хийцтэй байна.
- 6.2. Нуруу, хүзүүнд хэт ачаалал өгөх шахах төрлийн үйлдэлтэй тоног төхөөрөмжийг хориглоно. Нуруу, хүзүүнд хэт ачаалал өгөх төхөөрөмж нь нурууны нугасыг гэмтээх, бэртээх аюултай.
- 6.3. Чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийн төрөл, ангиллыг Хүснэгт 2-т үзүүлэв.
- 6.4. Гадна талбайн чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг төрлөөр нь статик болон динамик, зориулалтаараа нь зогсох, хэвтэх, суух, зүүгдэх гэж дөрөв ангилна.




Хөдөлгөөний орон зай

- 1. Дасгалын орон зай
- 2. Ашиглалтын хэсэг
- 3. Дасгалын давхацсан орон зай

Зураг 1. Хөдөлгөөний болон тоног төхөөрөмжийн орон зай (Жишээ зураг)







Зураг 2. Хүзүү, нугасанд ачаалал өгөх



Зураг 3. Нуруу, нугасанд ачаалал өгөх

Хүснэгт 2. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн төрөл /зориулалтаар/

	<p>Зогсож дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж (Жишээ зураг)</p>		<p>Сууж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж (Жишээ зураг)</p>
	<p>Хэвтэж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж (Жишээ зураг)</p>		<p>Зүүгдэж дасгал хийх зориулалт бүхий тоног төхөөрөмж (Жишээ зураг)</p>

6.5. Гадна талбайн чийрэгжүүлэх статик болон динамик тоног төхөөрөмжийг хамтад нь хослуулан байрлуулах боломжтой байдаг ба ингэснээр хэрэглэгчид нэг дор бүх төрлийн, иж бүрэн дасгал, хөдөлгөөнийг хийх боломжтой юм.

6.6. Статик болон динамик төрлийн тоног төхөөрөмжүүд нь ашиглалтын зориулалтаараа давуу болон сул талуудтай байдаг ба ашиглах явцад аюулгүй байдлыг хангах нь нэн чухал.

7. ХӨГЖЛИЙН БЭРХШЭЭЛТЭЙ ИРГЭНИЙ ХҮРТЭЭМЖТЭЙ БАЙДАЛ

7.1. Чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмж нь хөгжлийн бэрхшээлтэй иргэний хэрэгцээ, шаардлага, хүртээмжтэй байдлыг хангасан байх ба олон талт тоног төхөөрөмж байвал зохино.

7.2. Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан тоног төхөөрөмжийн загварыг Зураг 4-т үзүүлэв.



Зураг 4. Олон талт болон хөгжлийн бэрхшээлтэй иргэнд зориулсан чийрэгжүүлэх тоног төхөөрөмж (Жишээ зураг)

8. СТАТИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Статик төрлийн тоног төхөөрөмж нь загвар хийцийн хувьд хөдлөх хэсэггүй байдаг бөгөөд тоног төхөөрөмж дээр чийрэгжүүлэлтийн бүхий л төрлийн дасгалуудыг хийх боломжтой.



Зураг 5. Статик тоног төхөөрөмж (Жишээ зураг)

Статик тоног төхөөрөмжийн давуу талууд:

- Нэг төрлийн тоног төхөөрөмж дээр олон төрлийн дасгалууд хийх боломжтой;
- Хөдлөх хэсэггүй учир хийгдэх засвар үйлчилгээ бага;
- Хэрэглэгдэх хугацаа урт, эдэлгээ их;
- Эвдрэл, гэмтэл бага;
- Дасгал хөдөлгөөн хийхдээ нэмэлт хэрэгсэл (оосор, резин, уяа) ашиглах боломжтой;
- Хүүхдүүд тоглох, дасгал хийх боломжтой.

Статик тоног төхөөрөмжийн сул тал:

- Статик тоног төхөөрөмж дээр ихэвчлэн өөрийн биеийн жингээр дасгал хөдөлгөөн хийдэг;
- Төхөөрөмжийг ашиглахад тогтсон дасгал, хөдөлгөөн, заавар байдаггүй учир зарим талаараа гэмтэх, бэртэх эрсдэл үүсгэх магадлалтай.

9. ДИНАМИК ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ

Динамик тоног төхөөрөмж нь хийцийн хувьд хөдлөх хэсгүүдтэй байх ба дасгал хийхэд хөдөлгөөн нь жигд, тогтмол, хөдөлгөөний хязгаартай байдаг.



Зураг 6. Динамик тоног төхөөрөмж (Жишээ зураг)

Динамик тоног төхөөрөмжийн давуу талууд:

- Динамик тоног төхөөрөмж нь дасгал, хөдөлгөөний хязгаарлалттай байдаг учир зориулалтын дагуу ашиглахад гэмтэх, бэртэх эрсдэл бага байдаг;
- Тоног төхөөрөмж нь хэрэглэгчийн нас насны ангилалд тохирох сонголттой;
- Тухайн тоног төхөөрөмжийн дасгалыг хэрхэн яаж хийх нь ойлгомжтой байдаг.

Динамик тоног төхөөрөмжийн сул тал:





- Хэрэв хүүхдийн тоглоомын талбайн ойр динамик тоног төхөөрөмж байрлуулсан бол төхөөрөмж дээр хүүхэд тоглох, дасгал, хөдөлгөөний явцад оногдох, бэртэх, гэмтэх эрсдэлтэй;
- Цаг агаарын эрс, тэрс уур амьсгал нь динамик тоног төхөөрөмжийн ашиглалтын хугацааг багасгадаг бөгөөд засвар, үйлчилгээ их байдаг;
- Тоног төхөөрөмжийг хүний биеийн жин болон онцлогт тохируулан өөрчлөх боломжгүй байдаг.

10. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖ БАЙРЛУУЛАХ

10.1. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг цэцэрлэгт хүрээлэн, орон сууцны хорооллын ногоон бүсэд болон нийтийн эзэмшлийн гудамж талбайд төлөвлөн байршуулах бөгөөд дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:


- чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмжийг хүүхдийн тоглоомын талбайн зэргэлдээ байрлуулах бол хүүхдийн аюулгүй байдлыг хангах, гарч болох гэмтэл бэртлээс урьдчилан сэргийлж хашлага, хашаа, хайсаар зааглана;
- авто зам, инженерийн шугам сүлжээний өргөтгөл, шинэчлэлийн ажил хийгдэхээр төлөвлөж байгаа газарт байрлуулахгүй;
- чийрэгжүүлэлтийн талбайн тоног төхөөрөмжүүд төрлөөсөө хамааран өөр өөр ашиглалтын болон дасгалын бүстэй байх ба тоног төхөөрөмжийн төрөл, зориулалтаас хамааран хоорондын зайг тооцож байрлуулна;
- тоног төхөөрөмжийн төрөл, зориулалтаар ашиглалтын болон дасгалын орон зайн хэмжээг хүснэгт 3-т үзүүлэв.

Хүснэгт 3. Тоног төхөөрөмжийн ашиглалтын болон дасгалын орон зай

Зориулалтын төрөл	Радиус /мм/	Өндөр /мм/
 <p>Зогсох зориулалттай (Жишээ зураг)</p>	1000	2200
 <p>Суух зориулалттай (Жишээ зураг)</p>	1000	1500 (суудлаас эхэлнэ)
 <p>Зүүгдэх зориулалттай (Жишээ зураг)</p>	500	<p>Заасан 2200 өндрөөс дээш багадаа 300 мм зайг нэмнэ.</p> <p>Тайлбар: Тоног төхөөрөмж нь нийт өндрөөс дээш багадаа 300 мм сул орон зайтай байна.</p>
 <p>Хэвтэх зориулалттай (Жишээ зураг)</p>	1000	2200


11. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ СУУРИЛУУЛАХ

- 11.1. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн зааврын дагуу угсрах ба газарт хөдөлгөөнгүй, бат бэх суурилуулна.
- 11.2. Тоног төхөөрөмжийг суурилуулах болон угсрахдаа үйлдвэрлэгчийн зааврыг чанд мөрдөнө.
- 11.3. Тоног төхөөрөмжийн холбох хэрэгслүүд нь бат бөх, чанарын стандарт, шаардлага хангасан байх ёстой бөгөөд үйлчлүүлж буй хүн гэмтэх эрсдэлийг тооцоолсны үндсэн дээр суурилуулна.
- 11.4. Түгжээ, холбогч, хамгаалалтын бүрээс зэрэг нь бүрэн бүтэн, тусгай багаж хэрэглэхгүйгээр тайлж авах боломжгүй байх ба эрэг боолт бусад түгжих, бэхлэх зүйлс нь сулрах болон тайлагдахаас хамгаалагдсан байна.
- 11.5. Түгжээ, холбогч, хамгаалалтын бүрээс зэрэг нь ураг, хатгах, хувцас тээглэх эрсдэл учруулахааргүй байна.
- 11.6. Хөдөлгөөнт холбоосны хийц нь сулрах, мултрахаас хамгаалагдсан анкер боолтоор бэхэлсэн байна.



Зураг 7. Түгжээ, холбогч, хамгаалалт, ил гарсан хэсгийн зөвшөөрөгдсөн хэмжээ /мм-ээр/

- 11.7. Бүх түгжээснүүд зэврэлтээс хамгаалагдсан байх ба холбогдсон эд ангийн зэврэлтийг хамгийн бага хэмжээнд байхаар материалыг сонгоно.
- 11.8. Тоног төхөөрөмжийг угсарсны дараа хэрэглээнд оруулахаас өмнө мэргэжлийн байгууллагаар аюулгүй байдал болон аюулгүй ажиллагааг хянаж баталгаажуулсан байна.
- 11.9. Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн төрөл, эдлэхүүний нийт жингээс хамааран суурийн бетон эдлэлийн болон суурилуулалтын гүн, хэмжээг тооцон суурилуулна.



Түлхүүр үг:

- | | |
|---|------------|
| 1 | Гол багана |
| 2 | Гадаргуу |
| 3 | Суурь |

Зураг 8. Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн суурилуулалтын жишиг зураг

12. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН МАТЕРИАЛД ТАВИХ ШААРДЛАГА

- 12.1. Тоног төхөөрөмжийн будаг, хамгаалалтын химийн бодис нь эрүүл ахуйн шаардлага хангасан байна.
- 12.2. Тоног төхөөрөмж нь Монгол орны цаг уурын эрс тэс нөхцөлд тохиромжтой, байгаль орчинд хор нөлөөгүй материалаар хийгдсэн байна.
- 12.3. Тоног төхөөрөмжийн зааварт материалын талаарх хэрэглэгчдэд хүргэх мэдээллийг тусгасан байна.
- 12.4. Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмжийн эд зүйлд модон хийцээр хийгдсэн тохиолдолд хөрсний ялзралд тэсвэртэй модон материал сонгох бөгөөд модон хэсэглэлийг металл бэхэлгээ зэврүүлэх, ялзруулахаас хамгаалсан, эдэлгээг уртасгах зорилгоор ус чийг тусгаарлах зориулалт бүхий стандарт шаардлага хангасан будгаар технологийн дагуу будсан байна.
- 12.5. Тоног төхөөрөмжийн металл хийц, хэсгүүд нь зэвэрдэггүй материалаар хийгдсэн байх. Зэврэх магадлалтай хэсгийг стандарт шаардлага хангасан технологийн дагуу будсан байна.

13. ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙГ АШИГЛАХ ЗААВАР БОЛОН МЭДЭЭЛЛИЙН ХЭСЭГ


- 13.1. Чийрэгжүүлэлтийн тоног төхөөрөмж дээр дараах зөвлөмж болон мэдээллийг тусган байрлуулсан байна. Үүнд:
 - тухайн тоног төхөөрөмжийн үндсэн зориулалт, үүргийн талаарх мэдээлэл;
 - тоног төхөөрөмжийг ашиглах насны хязгаар болон өндрийн хэмжээ. /1400 мм-ээс дээш өдөр/;
 - тоног төхөөрөмжийг ашиглахад биеийн жингийн зөвшөөрөгдсөн дээд хязгаар;

- тухайн тоног төхөөрөмж дээр хийх дасгалын зааварчилгаа, зөвлөмжийн мэдээллийг зурган хэлбэрээр харуулах;
- дасгалыг хэрхэн хийх дарааллыг үзүүлсэн байх;
- дасгалыг хийснээр биеийн аль хэсэгт ачаалал өгөх талаарх мэдээллийг зурган хэлбэрээр үзүүлсэн байх;
- аюулгүй байдлын мэдээлэл. үүнд хориглох зүйлсийг тусгасан байна (жишээ нь: тоног төхөөрөмж дээр дасгал хийхдээ зориулалтын хувцастай байх, хувцаснаас илүү гарсан сул хэсэг, уяа, ханцуй зэргийг орооцолдохоос сэргийлэх гэх мэт).



Зураг 9. Тоног төхөөрөмж дээрх санамж, мэдээллийн хэсэг (Жишээ зураг)

- 13.2. Чийрэгжүүлэх талбайн орох хэсэг эсхүл аль тохиромжтой хэсэг, мэдээллийн самбар байрлуулсан байна.
- 13.3. Мэдээллийн самбарт хэрэглэгчдэд өгөх зөвлөгөө, заавар, дүрэм, санамж, сануулга, анхааруулга зэрэг мэдээллүүдийг тусгасан байна.
- 13.4. Хэрэглэгчдэд өгөх санамж, аюулгүй байдлыг хангах, мэдээллийн хэсгийг зураг 10-т үзүүлэв.




Зураг 10. Хэрэглэгчдэд зориулсан талбайн мэдээллийн самбар (Жишээ зураг)

- 13.5. Чийрэгжүүлэх талбай, тоног төхөөрөмжийг эзэмшигч болон хариуцагч байгууллага тоног төхөөрөмжийн суурилуулалт, засвар үйлчилгээ, материалын чанар, бусад шаардлагатай мэдээллийг хадгална.
- 13.6. Чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмж дээр эсхүл мэдээллийн самбарт хариуцагч байгууллагын нэр, хаяг болон холбоо барих утасны дугаарыг байршуулсан байна.

14. ЧИЙРЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙ НЭМЭЛТ ТОНОГЛОЛ

- 14.1. Чийрэгжүүлэх талбайн ойролцоо нийтийн эзэмшлийн сандал, хогийн сав байрлуулж болох ба хэрэглэгчдийн нягтаршил, эрчмээс шалтгаалан тоо хэмжээг тооцон байршуулна.
- 14.2. Нийтийн эзэмшлийн сандал нь UCS1407B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн сандалд тавих ерөнхий шаардлага”-ыг хангасан байна.
- 14.3. Чийрэгжүүлэх талбайд хогийн сав байрлуулах бол талбайн гадна талд байршуулна.
- 14.4. Хогийн савыг байрлуулахад UCS1406B:2022 “Нийтийн эзэмшлийн зам талбайн хогийн саванд тавих ерөнхий шаардлага”-ыг хангасан байна.
- 14.5. Гэрэлтүүлгийн зураг төслөөс эхлүүлэн архитектур дизайны үзэл баримтлалтайгаар төлөвлөнө.



Зураг 11. Нэмэлт гэрэлтүүлэг бүхий чийрэгжүүлэх талбай (Жишээ зураг)

- 14.6. Гэрэлтүүлгийн ган баганыг суурилуулахдаа чийрэгжүүлэх талбайн хэмжээ, тоног төхөөрөмжийн байршил зэргийг анхаарах шаардлагатай.
- 14.7. Гэрэлтүүлэг, гэрэлтүүлгийн шон, толгой, хүзүү нь гудамжны бусад хэсгийн өнгө дизайн загвартай уялдсан байна.
- 14.8. Гэрэлтүүлэг нь Монгол Улсын үндэсний стандарт “Гэрэлтүүлгийн ган багана. Техникийн шаардлага MNS 2568”-ийг мөрдлөг болгон UCS1902B:2022 “Гэрэлтүүлгийн тоног төхөөрөмжид тавих ерөнхий шаардлага”-ын дагуу хийж гүйцэтгэвэл зохино.

15. АШИГЛАЛТ, ЗАСВАР ҮЙЛЧИЛГЭЭ, ХЯНАЛТ


- 15.1. Нийтийн эзэмшилд байрлуулсан, чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийг хариуцагч байгууллага бүртгэх бөгөөд нийтийн эзэмшлийн эд хөрөнгийг бүртгэх, ашиглах журмыг мөрдлөг болгоно.
- 15.2. Нийтийн эзэмшлийн чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийн элэгдэл болон эвдрэлээс иргэдийг, осол гэмтэл учруулахаас урьдчилан сэргийлэх зорилгоор цэвэрлэгээ засвар үйлчилгээг тогтмол хийнэ.
- 15.3. Нийтийн эзэмшлийн чийрэгжүүлэх талбайн тоног төхөөрөмжийг зүй бусаар ашиглах, хохирол учруулах, сүйтгэх, устгах, гэмтээх, зүй зохисгүйгээр ашиглахыг хориглоно.
- 15.4. Чийрэгжүүлэлтийн талбай, тоног төхөөрөмжид хяналт, үнэлгээ хийх үзүүлэлтийг Хүснэгт 4-т үзүүлэв.

Хүснэгт 4. Тоног төхөөрөмжийн хяналт, үнэлгээ хийх үзүүлэлт

№	Хяналт үнэлгээ хийх чиглэл	Тийм	Үгүй
1	Тоног төхөөрөмж бохирдолтой байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Тоног төхөөрөмжид цэвэрлэгээ хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Тоног төхөөрөмж нь эвдэрч гэмтсэн, хугарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Тоног төхөөрөмжийн будаг болон гадаргуу хэсэг ховхроогүй, бүтэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Тоног төхөөрөмжийн холбоос болон төмөр хэсэг нь зэвэрсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Тоног төхөөрөмж болон түүний эргэн тойрон дахь талбайд хурц үзүүртэй зүйл байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Талбайн гадаргуу хэсэг цэвэр, эвдэрч гэмтсэн эсэх (нүх үүссэн, ховхорсон, халцарсан, гадаргуу нь нэгэн жигд бус)	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Тоног төхөөрөмжүүд бүрэн ажиллагаатай байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
9	Тоног төхөөрөмжийн бэхэлгээ найдвартай, зааврын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
10	Тоног төхөөрөмж дээрх зааварчилгаа болон мэдээлэл тодорхой харагдаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
11	Бэхэлгээ, эд анги, элэгдсэн, суларсан, гэмтсэн, мултарсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
12	Эвдэн сүйтгэх үйл ажиллагаанд өртсөн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
13	Талбайн цэвэрлэгээ хангалттай хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
14	Тоног төхөөрөмж дээр дасгал, хөдөлгөөн хийхэд бүрэн ажиллаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
15	Чийрэгжүүлэлтийн талбайн орчин аюулгүй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Тоног төхөөрөмж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол “Тийм” хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол “Үгүй” хэсгийг тэмдэглэнэ.

16. ЧИЙРЭГЖҮҮЛЭХ ТАЛБАЙН ТӨЛӨВЛӨЛТИЙН ЖИШИГ ЗАГВАР



Зураг 12. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар-1 (Жишээ зураг)



Зураг 13. Чийрэгжүүлэх талбайн төлөвлөлтийн жишиг загвар-2 (Жишээ зураг)



Зураг 14. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-1 (Жишээ зураг)



Зураг 15. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-2 (Жишээ зураг)



Зураг 16. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-3 (Жишээ зураг)



Зураг 17. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-4 (Жишээ зураг)



Зураг 18. Чийрэгжүүлэх талбайн жишиг загвар-5 (Жишээ зураг)

17. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

17.1. Чийрэгжүүлэх талбай, тоног төхөөрөмжийн материал, үйлдвэрлэлийн шаардлага, хэмжээ, байрлуулах, суурилуулах шаардлагыг хангаж байгаа эсэхийг дараах шалгуур үзүүлэлт (Хүснэгт5.)-ийн дагуу хянан шалгана.

Хүснэгт 5. Хүлээн авах шалгуур үзүүлэлт

№	Шалгуур үзүүлэлт	Тийм	Үгүй
1	Чийрэгжүүлэх талбай төлөвлөлтийн дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
2	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг зөв байрлалд, зөв байршуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
3	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийг үйлдвэрлэгчийн заавар, стандартын шаардлагын дагуу суурилуулсан эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
4	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмжийн зай хоорондын хэмжээ стандартад нийцэж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
5	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж материалын чанарын шаардлага хангаж байгаа эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
6	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж, модон хийц хэсгүүдэд байгалийн болон механик нөлөөллөөс хамгаалах будаг, түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
7	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж, металл хийц хэсгүүд зэвэрдэггүй материалаар хийгдсэн, эсхүл зэврэлтээс хамгаалах будаг түрхлэг стандартын дагуу хийгдсэн эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>
8	Чийрэгжүүлэх тоног төхөөрөмж нь чанарын баталгаа, гарал үүслийн гэрчилгээтэй эсэх	<input type="checkbox"/>	<input type="checkbox"/>

Тайлбар: Чийрэгжүүлэх талбай, тоног төхөөрөмж нь дээрх бүх шаардлагыг хангаж байх ёстой бөгөөд шаардлага хангасан бол **“Тийм”** хийгдээгүй буюу хийгдсэн боловч шаардлага хангахгүй байгаа бол **“Үгүй”** хэсгийг тэмдэглэнэ.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

- Ени 16630:2015 (Е) – Permanently installed outdoor fitness equipment – Safety requirements and test methods
- Park Fitness equipment plan City of Sydney 2030
- Guidelines for planning installing and activating outdoor fitness equipment /State of Victoria, Department of Health and Human Services June, 2018./
- <https://outdoorfitnessequipment.com.au/>
- <https://greatoutdoorgym.com/about-great-outdoor-gym/>



Нийслэлийн Засаг даргын хэрэгжүүлэгч агентлаг
ХОТЫН СТАНДАРТ, ХЯНАЛТЫН ГАЗАР



Хан-Уул дүүрэг, 23-р хороо, 17100, Наадамчдын зам
1200, Нутгийн захиргааны цогцолбор байр.



70118030, 70118040



www.standard.ub.gov.mn



Хотын стандарт, хяналтын газар